



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/41/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:

tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:

erdenechimegd@audit.gov.mn

Ахлах Аудитор

Д.Цэрэнханд

Утас: 99147999

Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	111,547.80	164,463.29
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,460,498.46	3,671,850.65
Нийт хөрөнгийн дүн	2,572,046.26	3,836,313.95
Нийт өр төлбөрийн дүн	-	2,599.76
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,572,046.26	3,833,714.19
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,572,046.26	3,836,313.95
Үйл ажиллагааны орлогын дүн	1,630,324.10	3,745,276.66
Үйл ажиллагааны зардлын дүн	1,770,219.90	2,179,608.73
Үйл ажиллагааны үр дүн	(139,895.80)	1,565,667.93
Үйл ажиллагааны бус үр дүн	-	304,000.00
Үйл ажиллагааны нийт үр дүн	(139,895.80)	1,261,667.93
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,572,046.3	2,572,046.3
Тайлант оны үр дүн	-	1,261,667.9
Эцсийн үлдэгдэл	2,572,046.26	3,833,714.19
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,553,252.60	2,093,774.50
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,529,572.60	2,026,301.91
Үйл ажиллагааны ЦМГ	23,680.00	67,472.59
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(23,680.00)	(55,860.00)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	11,612.59
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	11,612.59
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	11,612.59
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,524,585.8	2,081,835.1
Урсгал зардал	1,500,905.8	2,025,975.1
Хөрөнгийн зардал	23,680.0	55,860.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,524,585.8	2,093,447.66
Улсын төсвөөс санхүүжих	1,306,585.5	1,763,874.80
Орон нутгийн төсвөөс санхүүжих	218,000.3	320,674.06
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0	8,898.80
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	0	11,612.59

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 39.3 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 4.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 3 заалт албан шаардлага, 34.7 сая төгрөгийн зөрчилд 11 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлаган шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

- ✓ Амралтын цалин, үндсэн цалинг давхардуулан 4.0 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Замын хуудас, анхан шатны баримтын бүрдэл дутуу 0.7 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

- ✓ Байгууллагын гэрэл цахилгааны зардлыг 2.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бичгийн цаас, хувилагчийн зардлыг өмнөх оноос 6.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" 15.2.4-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төсвийн хөрөнгөөр 34.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан боловч гэрээний хугацаа дууссан, хөрөнгө нийлүүлэгдээгүй байхад ирснээр тоолж, нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил гараагүй болно.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Есөнбулаг сумын 3 дугаар сургууль	2	35.4	1	0.7	1	34.4	2	35.4				
Дүн	2	35.4	1	0.7	1	34.4	2	35.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Есөнбулаг сумын 3 дугаар сургууль	5	39.4	2	4.6	3	34.7						
Дүн	5	39.4	2	4.6	3	34.7						

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		